

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянтээг ХК 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2024/08/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Арвайхээр хот 2024 он	Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn Аудитор: Э.Энхбаяр Утас: 70323833 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын өрдөг, Л.Гандангийн гудамж,
5 дугаар байр, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 82173
Утас/Факс: (976) 7032 3253
Цахим шуудан: ovorkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.25 № 147

Тангай _____ -ны № _____ -т

БАЯНТЭЭГ ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ч.ГАНХУЯГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянтээг ХК-ний 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянтээг ХК-ний 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баянтээг ХК нь 2023 онд уурхайгаас нийт 230 мянган тн нүүрс олборлон борлуулж, 10,417.5 сая төгрөгийн орлоготой ажиллахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 287.3 мянган тн нүүрс борлуулж, 13,247.7 сая төгрөг орж өмнөх оны гүйцэтгэлээс 50.5 хувиар өссөн байна. 2023 онд нэг тонн нүүрсийг 25.5 мянган төгрөгөөр олборлон 45.0 мянган төгрөгөөр борлуулж нүүрс борлуулалтын нэгж тутмаас 20.0 мянган төгрөгийн ашигтай ажиллажээ. Өнгөрсөн оны мөн үеэс нэг тонн нүүрсний өртөг 7.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Баянтээг ХК-ийн нүүрсний нөөц өсгөх, чанарын судалгааны ажлыг Майн валюшн энд консалтинг ХХК гүйцэтгэсэн бөгөөд Эрдэс баялгийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, ашигт малтмалын ордын нөөцийн тооцоо бүхий тайланг боловсруулах шатны ажил хийгдэж байна

015000714

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31.
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	7,052,339.5	11,879,385.9
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,133,980.7	5,826,497.6
Нийт хөрөнгийн дүн	13,186,320.2	17,705,883.5
Нийт өр төлбөрийн дүн	1,127,674.5	2,377,006.3
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	12,058,645.7	15,328,877.2
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	13,186,320.2	17,705,883.5
Санхүүгийн орлого үр дүнгийн тайлан		
Борлуулалтын орлогын дүн	8,804,259.7	13,247,670.6
Борлуулалтын өртөг	4,681,669.6	7,340,535.6
Нийт ашиг алдагдал	4,122,590.1	5,907,135.1
Татварын дараахь ашиг алдагдал	2,539,834.1	3,270,231.6
Орлогын нийт үр дүн	2,539,834.1	3,270,231.6
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Залруулсан үлдэгдэл	9,518,811.6	12,058,645.7
Тайлант үеийн цэвэр ашиг	2,539,834.1	3,270,231.6
Эцсийн үлдэгдэл	12,058,645.7	15,328,877.2
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	9,721,154.9	14,426,574.2
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	8,615,544.6	12,499,761.5
Үйл ажиллагааны ЦМГ	1,105,610.2	1,926,812.7
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(1,191,686.7)	(186,760.3)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(21,264.9)	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(107,341.4)	1,711,350.0
Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,144,375.6	3,037,034.2
Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,037,034.2	4,748,384.2

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ:

Аудитаар нийт 1,049.6 сая төгрөгийн 3 зөрчилд 3 албан шаардлага хүргүүлсэн

3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт:

Тайлант онд 1,950.0 мянган төгрөгийн гар утасны нэгж худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно.” 12.1.1-д “гар утасны зардал,” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Тайлант онд олгосон 1950.0 мянган төгрөгийн нэгжийн төлбөрийг холбогдох албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт хүргүүлэх.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баянтээг ХК	4	72,549.5	1	1,950.0	3	70,599.5	0	0	0	0	0	0
Дүн	4	72,549.5	1	1,950.0	3	70,599.5	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Баянтээг ХК	0	0	0	0	0	0	0	0
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Баянтээг ХК	1	977,100.6	0	0	1	977,100.6	0	0
Дүн	1	977,100.6	0	0	1	977,100.6	0	0
Нийт дүн	4	1,049,650.1	1	1,950.0	3	1,047,700.1	0	0

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Төсөл, хөтөлбөр		1			1			
2	ЗГТС								
3	ТТЗ								
	НИЙТ		1			1			

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ-ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6217143681
ИЮА0059 9044094